



КАРЕК-ИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН УУЛЗАЛТ
2026 оны 6 дугаар сарын 11-12 | Монгол Улс, Улаанбаатар хот

Даргалагч: Хатагтай С.Даваасүрэн
Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн дэд сайд
Дэмжлэг үзүүлсэн: Хатагтай Лиа Гутьеррез
Газрын захирал, Төв болон Баруун Азийн газар, Азийн хөгжлийн банк

Ноён Мухаммад Эхсан Хан
Газрын захирал, Зүүн Азийн газар, Азийн хөгжлийн банк

ҮНДЭСЛЭЛ БА ЗОРИЛГО

2026 оны КАРЕК-ийн Удирдах албан тушаалтнуудын уулзалт (УАТУ) нь 2026 оны 9 дүгээр сард төлөвлөгдсөн КАРЕК-ийн Сайд нарын 25 дугаар бага хурал (СБХ)-д бэлтгэх чухал платформ бөгөөд КАРЕК-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны 25 жилийн ойн чухал түүхэн үеийг тэмдэглэж байна.

УАТУ нь Үндэсний зохицуулагч (ҮЗ)-ид, хөгжлийн түншүүд болон салбарын шинжээчдийг нэг дор цуглуулж, 2026 оны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, ахиц дэвшлийг хэлэлцэх, СБХ-ын анхаарлыг үр дүнд суурилсан, тодорхой санхүүжих боломжтой төсөл, хөтөлбөрүүд дээр төвлөрүүлэх, КАРЕК-ийн гишүүн орнууд болон хөгжлийн түншүүдийн оролцоог гүнзгийрүүлж, хариуцлагыг бэхжүүлэх зорилготой юм.

Тодруулбал, УАТУ-ын хүрээнд 2026 онд хэрэгжүүлсэн байх тэргүүлэх чиглэлүүдийг авч хэлэлцэнэ. Үүнд: 24 дүгээр СБХ-ын үеэр гарын үсэг зурсан Харилцан ойлголцлын санамж бичгүүдийн хэрэгжилт, түүнчлэн Интеграци, логистик болон хөгжлийн төлөх хилийн боомтуудын шинэчлэл (BUILD)-ийн сан, Чухал ашигт малтмалаас үйлдвэрлэл хүртэлх санхүүжилтийн түншлэлийн сан, Бүс нутгийн аялал жуулчлал, Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн форум зэрэг шинэ санаачилгуудыг хэлэлцэнэ.

Тус уулзалтаар КАРЕК-ийн 2030 оноос хойшхи алсын харааны талаарх хэлэлцүүлгийг эхлүүлж, 25 жилийн ойг геополитикийн өөрчлөлт, уур амьсгалын хэрэгцээ шаардлага, цахим шилжилт, худалдааны динамикийн хувьсал болон шинээр гарч ирж буй салбаруудад чиглэсэн ирээдүйтэй хөтөлбөрийг боловсруулах боломж болгон ашиглана.

КАРЕК-ИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН УУЛЗАЛТ

2026 оны 6 дугаар сарын 11-12 | Монгол Улс, Улаанбаатар хот

2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн байдлаарх хөтөлбөр

1 дүгээр өдөр: 2026 оны 6 дүгээр сарын 11 (пүрэв гараг)	
Байршил: Шангри-Ла зочид буудал, Боллрүүм 1 танхим, Улаанбаатар, Монгол Улс	
08:30 – 09:00	Бүртгэл
09:00 – 09:20	НЭЭЛТ <i>Нээлтийн үг</i> Хатагтай С.Даваасүрэн Монгол Улсын Засгийн газрын Эдийн засаг, хөгжлийн дэд сайд <i>Нээлтийн үг</i> Хатагтай Лиа Гутиеррез Газрын захирал, Төв болон Баруун Азийн газар (ТБАГ), Азийн хөгжлийн банк (АХБ)
09:20 – 10:20	1 дүгээр хэлэлцүүлэг: КАРЕК-ийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх болон КАРЕК-ийн үндэсний зохицуулагчид (ҮЗ-ид)-ын үүрэг оролцоог бэхжүүлэх нь Энэхүү хэлэлцүүлгээр 2025 оноос хойш КАРЕК хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тохирсон арга хэмжээнүүдийг танилцуулж, гол төлөвлөсөн төслүүдийн жагсаалтын талаар илтгэнэ. Үүнд АХБ-наас 2026-2030 онд КАРЕК хөтөлбөрийг дэмжих зорилгоор 10 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх зорилтын талаар авч хэлэлцэнэ. Хэлэлцүүлэг нь холболт, эрчим хүч, цахим шилжилт, уур амьсгалын тэсвэртэй байдал, хүний хөгжил зэрэг 2030 он хүртэлх КАРЕК-ийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох хөрөнгө оруулалтын стратегийн салбарууд болон коридоруудын дагуух арга хэмжээнүүдэд төвлөрнө. Модератор: Хатагтай Д.Эрдэнэтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Монгол Улс Илтгэгч: Ноён Асад Алим, АХБ-ны ТБАГ-ын Бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграци хариуцсан бүсийн дарга (10 минут) <u>Нээлттэй хэлэлцүүлэг (30 минут)</u> <i>КАРЕК-ийн ҮЗ бүрт 3 минут олгоно. Дараах асуултууд хэлэлцүүлгийг чиглүүлэхэд тусална, үүнд:</i> <ol style="list-style-type: none"><i>Бүс нутгийн хөрөнгө оруулалтын төслүүдийг боловсруулахад КАРЕК хөтөлбөр нь хэрэгжилт, түншлэл болон санхүүжилтийн хөшүүргийг хэрхэн бэхжүүлэх вэ?</i><i>Улс орны хөтөлбөрийг КАРЕК-ийн бүс нутгийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцүүлэхэд КАРЕК-ийн орнуудад хэрэгжиж буй сайн туршлага юу вэ, мөн салбарын яамд хоорондын зохицуулалтыг хангахад ҮЗ-үүдийн үүрэг юу вэ?</i>

	<p>3. <i>Сайн санааг төслийн тодорхой үзэл баримтлал болгон хувиргах, санхүүжилт босгох, төслийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн хөнгөөчлөх, үр дүнтэй болгох вэ?</i></p> <p>КАРЕК-ийн Ажлын алба болон/эсвэл Хөгжлийн түншүүдийн хариулт (20 минут)</p>
10:20– 10:35	<p>Дурсгалын зураг ба цайны завсарлага</p>
10:35 – 11:50	<p>2 дугаар хэлэлцүүлэг: Тээвэр ба цахим холболтыг хурдасгах</p> <p>Энэхүү хэлэлцүүлгээр КАРЕК-ийн Тээврийн стратеги 2030-ийн дунд хугацааны хяналт-шинжилгээний явц, 2025 оны 11 дүгээр сард байгуулсан Санамж бичгийн дагуу <i>КАРЕК-ийн Цахим коридорын</i> урьдчилсан ТЭЗҮ-ийн эхний үр дүнг хэлэлцэж, Тээврийн салбарын зохицуулах хороо (ТСЗХ)-ны сүүлийн уулзалтын үр дүнг танилцуулна.</p> <p>Хэлэлцүүлэг нь BUILD сангийн тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, КАРЕК-ийн 2 дугаар коридорыг хөгжүүлэх хандлагын хүрээн дэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, цахим логиستيкийн хамрах хүрээг тогтоох судалгаа болон бусад тээвэр, цахим санаачилгуудад төвлөрнө.</p> <p>Модератор: Ноён Мухаммад Эхсан Хан, Газрын захирал, Зүүн Азийн газар (ЗАГ), АХБ</p> <p>Илтгэгчид: Ноён Чен Чен, Захирал (Төв болон Баруун Ази, Зүүн Ази ба Номхон далайн бүс), Салбарын 1 дүгээр газрын Тээврийн салбарын алба, АХБ болон Ноён М.Баярмагнай, Төрийн нарийн бичгийн дарга, Зам, тээврийн яам, Монгол Улс (10 минут) Ноён Антонио Забаллос, Захирал, Салбарын 2 дугаар газрын Цахим салбарын алба, АХБ (10 минут) (цахимаар)</p> <p><u>Нээлттэй хэлэлцүүлэг (30 минут)</u></p> <p><i>КАРЕК-ийн ҮЗ бүрт 3 минут олгоно. Дараах асуултууд хэлэлцүүлгийг чиглүүлэхэд тусална, үүнд:</i></p> <ol style="list-style-type: none"> <i>1. Дэд бүтцийн холболтын төсөл болон цахим/МХХТ-н санаачилгуудын хэрэгжилтийг хурдасгахад улс бүр хэрхэн хувь нэмэр оруулах вэ (жишээ нь, бодлогын шинэчлэл, зохицуулалтын уялдаа холбоо)?</i> <i>2. Тээврийн холболтыг сайжруулах, КАРЕК-ийн өөр өөр коридоруудын уялдаа холбоог хангах бусад боломж, механизмууд юу вэ, мөн дэлхий дахинд өөрчлөгдөж буй тодорхойгүй байдалд хэрхэн илүү сайн хариу үйлдэл үзүүлэх вэ?</i> <i>3. КАРЕК-ийн Цахим коридороос бүрэн ашиг хүртэхийн тулд үндэсний түвшинд ямар гол шинэчлэлүүд шаардлагатай вэ? Цахим коридорыг бусад түншүүд болон санаачилгуудтай хэрхэн илүү сайн уялдуулах вэ?</i> <p>КАРЕК-ийн Ажлын алба болон/эсвэл Хөгжлийн түншүүдийн хариулт (25 минут)</p>
11:50 – 12:55	<p>3 дугаар хэлэлцүүлэг: КАРЕК-ийн худалдаа, аялал жуулчлалын хөтөлбөрийг урагшлуулах нь</p>

Энэхүү хэлэлцүүлгээр КАРЕК-ийн Худалдааны нэгдсэн хөтөлбөр 2030-ийн хэрэгжилтийн явцыг хянаж, Бүс нутгийн худалдааны бүлэг болон Гаалийн хамтын ажиллагааны хорооны хамтарсан уулзалтын үр дүн, 2025 оны 11 дүгээр сарын КАРЕК-ийн Сайд нарын бага хурлын үеэр гарын үсэг зурсан Харилцан ойлголцлын санамж бичгүүдийн хэрэгжилтийн явцыг танилцуулна. Үүнд КАРЕК-ийн Худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх түншлэлийн хэлэлцээр (CARTIF)-ийг эхлүүлэх тухай Бишкекийн тунхаглал, КАРЕК-ийн Бүс нутгийн аялал жуулчлал, КАРЕК-ийн Дамжин өнгөрөх тээврийн ахисан түвшний систем ба Мэдээлэл солилцох дундын систем (CATS/ICE), цахим гэрчилгээ олголт ба тохирлын гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх туршилтын хөтөлбөр, болон бусад тэргүүлэх санаачилгууд (ДХБ-д элсэх болон хэрэгжилт) багтана.

Хэлэлцүүлэг нь худалдааны бодлогын шинэчлэл дэх КАРЕК-ийн тэргүүлэх чиглэлүүд, бүс нутгийн аялал жуулчлалын кластеруудын хэрэгжилт, Самарканд хотноо болсон АХБ-ны Жилийн уулзалтын үеэрх КАРЕК-ийн хэлэлцүүлгийн үр дүнд төвлөрнө.

Модератор: Хатагтай Лиа Гутьеррез, Газрын захирал, ТБАГ, АХБ

Илтгэгчид:

Ноён И.Батхүү, Төрийн нарийн бичгийн дарга, Эдийн засаг, хөгжлийн яам (10 минут)

Ноён Г.Энхтайван, Гаалийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга (КАРЕК-ийн ГХАХ-г даргалагч) (10 минут)

Нээлттэй хэлэлцүүлэг (30 минут)

КАРЕК-ийн ҮЗ бүрт 3 минут олгоно. Дараах асуултууд хэлэлцүүлгийг чиглүүлэхэд тусална, үүнд:

- 1. Худалдааны бодлого, худалдааг хөнгөвчлөх санаачилгуудыг хэрэгжүүлэх, түүний дотор бодлогын уялдаа холбоо, бүс нутгийн хамтын ажиллагааг хангахад улс бүр хэрхэн хувь нэмэр оруулах вэ?*
- 2. КАРЕК хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын бүс нутгийн ямар санаачилгууд болон шинээр гарч ирж буй хөрөнгө оруулалтын чиглэлүүдийг хөгжүүлж болох вэ?*
- 3. Худалдаа, аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийг хурдасгаж, бүс нутгийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд КАРЕК төслийн хэрэгжилт, түншлэл, санхүүжилтийн хөшүүргийг хэрхэн цаашид бэхжүүлэх вэ?*

КАРЕК-ийн Ажлын алба болон/эсвэл Хөгжлийн түншүүдийн **хариулт** (25 минут)

12:55 – 14:00	Үдийн хоол <i>Байршил: Шангри-Ла зочид буудал, Кафе Парк ресторан</i>
14:00 – 15:00	4 дүгээр хэлэлцүүлэг: Эрчим хүчний аюулгүй байдал, бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх ба эрчим хүчний салбар болон чухал ашигт малтмалын өртгийн сүлжээн дэх хувийн хэвшлийн хөгжил

Энэхүү хэлэлцүүлэг нь эрчим хүчний салбар болон чухал ашигт малтмалын бүс нутгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, КАРЕК-ийн орнуудын үндэсний эрчим хүчний шилжилтийг хурдасгахад улс орнуудын тэргүүлэх чиглэл, тулгарч буй бэрхшээл, дэмжлэг авах хэрэгцээг тодорхойлоход чиглэнэ. Мөн АХБ-ны Чухал ашигт малтмалаас үйлдвэрлэл хүртэлх санхүүжилтийн түншлэлийн шинэ сан нь КАРЕК-ийн бүс нутгийн өртгийн сүлжээг хөгжүүлэхэд хэрхэн урт хугацааны дэмжлэг үзүүлж болох талаар хэлэлцэнэ. Хэлэлцүүлгээр чухал ашигт малтмал, эрчим хүчний аюулгүй байдал, холболтын чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх бусад боломжуудыг тодорхойлно.

Модератор: Ноён Айминг Жоу, АХБ-ны БНХАУ дахь Суурин төлөөлөгчийн газрын Орлогч дарга

Илтгэгчид:

Ноён Серик С. Жаркинбаев, Эрчим хүчний мэргэжилтэн, Салбарын 1 дүгээр газар, АХБ (5 минут) (цахимаар)

Ноён Кванг Жо (КЖ) Жонг, Бүс нутгийн хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн, Уур амьсгалын өөрчлөлт ба тогтвортой хөгжлийн газар, АХБ (цахимаар), мөн Ноён Хосе Карлос Эдо Монфорт, Эрчим хүчний ахлах мэргэжилтэн, Эрчим хүчний шилжилт – Салбарын бүлэг, АХБ (10 минут)

Нээлттэй хэлэлцүүлэг (30 минут)

КАРЕК-ийн ҮЗ бүрт 3 минут олгоно. Дараах асуултууд хэлэлцүүлгийг чиглүүлэхэд тусална, үүнд:

- 1. Тэргүүлэх хэрэгцээ болон хязгаарлагдмал хүчин зүйлүүд:** (i) Танай улсын эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрчим хүчний шилжилтийг урагшлуулахад тулгарч буй гол тэргүүлэх чиглэл, бэрхшээлүүд юу вэ? (ii) Эрчим хүчний холболт, чухал ашигт малтмал эсвэл өртгийн сүлжээг хөгжүүлэхтэй холбоотой танай улсын тэргүүлэх санаачилгууд юу вэ? (iii) Гол хязгаарлагдмал хүчин зүйлүүд нь юу вэ (жишээ нь: санхүүжилт, дэд бүтэц, зохицуулалтын орчин, хил дамнасан зохицуулалт)?
- 2. Хувийн хэвшлийн оролцоо:** (i) Танай тэргүүлэх салбаруудад хувийн хэвшлийн оролцоог татахад тулгарч буй гол саад бэрхшээл юу вэ? (ii) АХБ-наас үзүүлэх ямар тодорхой дэмжлэг эдгээр саад бэрхшээлийг шийдвэрлэхэд тусалж болох вэ?
- 3. Бүс нутгийн хамтын ажиллагааны боломжууд:** (i) Хил дамнасан хамтын ажиллагааны ямар тодорхой боломжууд (жишээ нь: дундын дэд бүтэц, худалдаа, нэгдсэн өртгийн сүлжээ) байна гэж та үзэж байна вэ? (ii) КАРЕК эдгээр чиглэлээр ахиц гаргахад хэрхэн тусалж болох вэ?

КАРЕК-ийн Ажлын алба болон/эсвэл Хөгжлийн түншүүдийн **хариулт** (15 минут)

15:00-
16:00

5 дүгээр хэлэлцүүлэг: КАРЕК дахь хөгжлийн түншүүдийн үүрэг оролцоог бэхжүүлэх нь

Чиглүүлэгч: Хатагтай Д.Эрдэнэтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Монгол Улс

	<p>Энэхүү хэлэлцүүлэг нь КАРЕК-ийн орнууд болон хөгжлийн түншүүдэд төслийн тодорхой жагсаалтыг хэлэлцэх, санхүүжилтийг бүс нутгийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцүүлэх боломжийг олгоно. Эдгээр хэлэлцүүлгийн үр дүн нь КАРЕК-ийн Хөгжлийн түншүүдийн форум болон/эсвэл КАРЕК-ийн Бизнес форум, мөн бүс нутгийн бодлогын хэлэлцүүлгүүд зэрэг төсөл, санаачилгууд дээр хөгжлийн түншүүдийн хамтын ажиллагааг сайжруулах үндэс суурийг тавина.</p> <p>2025 оны 11 дүгээр сард болсон КАРЕК-ийн Сайд нарын 24 дүгээр бага хурлын дагалдах хөгжлийн түншүүдийн хэлэлцүүлгийн мөрөөр хөгжлийн түнш бүр КАРЕК 2030-ийн тэргүүлэх чиглэлийг дэмжих санаачилгад гүйцэтгэх үүрэг, тодорхой саналуудаа хэлэлцэх бөгөөд үүнд дараах асуудлууд багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Сонгогдсон КАРЕК-ийн бүлэг, сэдэв, салбарын ажлын хэсгүүдийг дэмжих • КАРЕК-ийн Бизнес эсвэл Хөгжлийн форумын хэлэлцүүлгүүдийг хамтран даргалах • КАРЕК-ийн техникийн туслалцаа болон/эсвэл төсөл бэлтгэх сангуудад хамтарсан санхүүжилт дайчлах • КАРЕК төслийн хянах самбар болон харилцаа холбоо
16:00 – 16:15	Цайны завсарлага
16:15 – 17:30	Үндэсний зохицуулагчдад зориулсан хаалттай хэлэлцүүлэг
18:00 – 20:00	<p>Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулах оройн хүлээн авалт Байршил: Зү Боллрүүм (Ballroom Zu) Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимп-5</p>
<p>2 дахь өдөр, 2026 оны 6 дугаар сарын 12 (Баасан гараг) Байршил: Шангри-Ла зочид буудал, Боллрүүм 1 танхим, Улаанбаатар, Монгол Улс</p>	
09:00 – 10:00	<p>6 дугаар хэлэлцүүлэг: Ирээдүйн санхүүжилт — хөрөнгийн зах зээл, гамшгийн эрсдэлийн санхүүжилт, нүүрстөрөгчийн худалдаанд бэлэн байх ба шинэлэг санхүүжилт татах нь</p> <p>Энэхүү хэлэлцүүлэг нь бүс нутгийн хөгжлийн санхүүжилтийг дайчлах буюу салбар хоорондын гол тэргүүлэх чиглэлд төвлөрнө. Хэлэлцүүлгээр КАРЕК хөтөлбөр өөрийн хөрөнгө оруулалтын төслүүдийг дэмжихэд шинэлэг санхүүжилтийг хэрхэн ашиглах талаар авч үзнэ. Хэлэлцүүлэгт Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн форумыг шинэчлэх, бүс нутгийн гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн төслүүдийг өргөжүүлэх, Нүүрстөрөгчийн зах зээлд бэлэн байх төлөвлөгөө, КАРЕК-ийн Инноваци болон венчур хөрөнгө оруулалтын катализатор (CIVIC) сан зэрэг асуудлуудыг багтаана.</p> <p>Чиглүүлэгч: Ноён Б.Дөлгөөн, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлийн газрын дарга, Монгол Улс</p> <p>Илтгэгчид:</p> <ul style="list-style-type: none"> • Ноён Мохд Сани Мохд Исмайл, АХБ-ны Салбарын 3 дугаар газрын Санхүүгийн салбарын албаны захирал (15 минут) • Ноён Кристиан Росбах, Бүс нутгийн хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн, АХБ (5 минут) (цахимаар)

	<p><u>Нээлттэй хэлэлцүүлэг (30 минут)</u></p> <p><i>КАРЕК-ийн ҮЗ бүрт 3 минут олгоно. Дараах асуултууд хэлэлцүүлгийг чиглүүлэхэд тусална, үүнд:</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Бүс нутагт гүнзгий бөгөөд хөрвөх чадвартай хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээл юу вэ? 2. КАРЕК хөтөлбөр нь улс орнуудад хувийн болон институциональ хөрөнгө оруулалтыг татах санхүүжих боломжтой төслүүдийг бэлтгэхэд хэрхэн туслах вэ? Үүний зэрэгцээ CIVIC санг ашиглан ЖДҮ болон шинээр гарч ирж буй гарааны бизнесийн экосистемийг хэрхэн дэмжих вэ? 3. КАРЕК-ийн гишүүд санхүүгийн бэлэн байдлыг дээшлүүлж, уур амьсгалтай холбоотой цочролын төсөвт үзүүлэх нөлөөллийг бууруулах бүс нутгийн гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн шийдлүүдийг боловсруулахад хэрхэн хамтран ажиллах вэ? 4. Бүс нутгийн ногоон шилжилтийг санхүүжүүлэхэд нүүрстөрөгчийн зах зээл ямар үүрэг гүйцэтгэж болох вэ? <p>КАРЕК-ийн Ажлын алба болон/эсвэл Хөгжлийн түншүүдийн хариулт (10 минут)</p>
<p>10:00– 11:00</p>	<p>7 дугаар хэлэлцүүлэг: КАРЕК-ийн сайд нарын бага хурлын бэлтгэл — түншлэлийн 25 жил: ирээдүйг хамтдаа цогцлоох нь</p> <p>Чиглүүлэгч: Хатагтай Лиа Гуттиеррез, Газрын захирал, ТБАГ, АХБ</p> <p>Энэхүү хэлэлцүүлэг нь КАРЕК-ийн 25 жилийн ойг угтах тодорхой үйл ажиллагааг бэлтгэх болон 2030 оноос хойшхи КАРЕК-ийн алсын хараанд төвлөрнө.</p> <p><u>Нээлттэй хэлэлцүүлэг</u> ба чөлөөт ярилцлага (60 минут)</p> <p><i>КАРЕК-ийн бүх ҮЗ-уудыг дараах тодорхой салбаруудад ач холбогдол өгч, санал бодол, байр сууриа хуваалцахыг уриална, үүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> • Худалдаа ба коридорын холболт • Цахим болон эрчим хүчний коридорууд • Санхүүжилт болон хувийн хэвшлийн хөгжил • Стратегийн шинэ салбарууд
<p>11:00– 11:15</p>	<p>Нэгдсэн дүгнэлт ба хаалтын ажиллагаа</p> <ul style="list-style-type: none"> • Ноён Мухаммад Эхсан Хан, Газрын захирал, ЗАГ, АХБ • Хатагтай С.Даваасүрэн, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Монгол Улс
<p>11:15- 12:00</p>	<p>Үдийн хоол Байршил: Шангри-Ла зочид буудал, 1 дүгээр давхар, Кафе Парк ресторан</p>